



# СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

# МЭДЭЭ

№09 /223/

2022.01.11

Цаг үе, үйл явдал

Түүхэнд энэ өдөр

1938 он.

“Яамны өдөрт тутмын жижүүрүүдээс албан хаагчдыг хэрхэн бүтгэх журмыг тогтоох тухай” Цэргийн явдлын яамны сайд, Бүх цэргийн жанжны орлогчийн 3 тоот тушаал гарчээ.

## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ӨВЛИЙН “ОЛИМП” ГАРААНААС...



Цэрэгжлийн спортын өвлийн 2 төрөлт болох биатлон, патруль болон ЦСЦ-ын өвлийн олон төрөлтийн тэмцээний нээлтийн арга хэмжээ өчигдөр боллоо. Нээлтэд ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга

бригадын генерал С.Ганбямба, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч хошууч генерал О.Энхбаяр болон бусад албан тушаалтнууд оролцлоо. Хоёр жилд нэг удаа зохион



байгуулагддаг уг тэмцээнд энэ жил Зэвсэгт хүчний 24 нэгтгэл, ангийн 300 орчим тамирчин хурд хүч, авхаалж самбаагаа сорин оролцож байгаа бөгөөд тэмцээн Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн

байрлалд зохион байгуулагдаж байна. Ташрамд дурдахад нээлтийн үеэр өнгөрсөн жилийн эл тэмцээнд тэргүүлсэн анги, салбар, алба хаагчдын шагналыг гардуулан өгсөн юм.



## АНГЛИ ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ТӨВҮҮДИЙН ХИЧЭЭЛ ЭХЭЛЛЭЭ

Монгол Улсын Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал, АНУ-ын Энэтхэг-Номхон далайн Хуурай замын цэргийн командлал хоорондын хамтын ажиллагааны хүрээнд англи хэлний сургалтын төвүүд шинээр байгуулагдаад байгаа билээ. Энэ нь АНУ-ын талаас англи хэлний сургалтад ашиглагдах тоног төхөөрөмжийг өгсний дагуу ХЗЦК болон Зэвсэгт хүчний 014 дүгээр ангид тус төвүүдийг тоноглон үйл ажиллагааг нь эхлүүлээд байгаа юм. Тодруулбал, Хуурай замын цэргийн командлалын Англи хэлний сургалтын төв өчигдрөөс дамжаагаа эхлүүлсэн бөгөөд нээлтийн арга хэмжээнд Хуурай замын цэргийн штабын дарга бригадын генерал Л.Онцгойбаяр оролцож, суралцагчдад амжилт хүсэв. Сургалтад Хуурай замын цэргийн командлал болон харьяа нэгтгэл, ангиудын 40 орчим офицер, ахлагч хамрагдаж байгаа бөгөөд Зэвсэгт хүчний Гадаад хэлний

сургалтын төвийн хөтөлбөрөөр хичээл явагдах юм. Бригадын генерал Л.Онцгойбаяр хэлсэн үгэндээ, “Юуны өмнө сургалтад хамрагдаж буй офицер, ахлагч нартаа баяр хүргэе. Нэгтгэл, ангиасаа шигшигдэж ирсэн, сурч мэдэхийн төлөөх туйлын хүсэлтэй залуус зорин ирсэн гэдэгт итгэлтэй байна. Өнөөдөр та бидний суралцах гэж байгаа энэ төвүүдийг байгуулахын төлөө Хуурай замын цэргийн командлал болоод Зэвсэгт хүчний Жанжин штаб гурван жилийнхээ хөдөлмөрийг зарцуулсан. Одоо харин та бүхэн сурсан шиг сурах ёстой. Долоо хоног бүрийн төгсгөлд шалгалт авч, бага үнэлгээтэй офицер, ахлагч нараа нэгтгэл, анги руу нь буцаана. Сайн сурч чадвал та нарыг сайхан ирээдүй хүлээж байна” гэж онцлоод командлал болоод Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн дотоод журмыг баримталж, аюулгүй байдлаа алхам тутамдаа

сахиж байхыг санууллаа. Үүний дараа Хуурай замын цэргийн ахлагч, тэргүүн ахлагч Д.Мөнхбаяр, тус командлалын Цэргийн сургалт, соёл хүмүүжлийн хэлтсийн дарга хурандаа Т.Тогмиддүүмий нар суралцагчдад анхаарах асуудлыг танилцуулж, энэ

төвүүдийн цаашдын зам мөр, үйл ажиллагаа та бүхний идэвх, чармайлт, зүтгэлээс ихээхэн хамаарна гэдгийг тодотголоо. Мөн сургалтын төвүүд нь сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр хангагдсан нь гол давуу чанар гэв. **Ахлах дэслэгч Д.БОЛОРМАА**



## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН  
2.266.992 /69.7%/

ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН  
2,166.296 /66.6%/

ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН  
936.906 28,8%

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН  
7395 +112

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ  
213

ЭДГЭРСЭН  
7066

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол  
Нийт: 311,000,664

Эдгэрсэн  
Нийт: 260,540,827

Нас барсан  
Нийт: 5,511,865

ӨВЛИЙН АДАГ ЦАГААГЧИН ҮХЭР САРЫН НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ХӨХ ХУЛГАНА ӨДӨР

Үс засуулбал:  
Өвчин өчүүхэн ирнэ  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:  
08.39-17.21  
БАРИЛДЛАГА: Арвидах  
ШҮТЭН БАРИЛДЛАГА:  
Авахуй  
Суудал: Гал

Энэ өдөр луу жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, хүү сангийн эх хатгах, эд агуурс авах, зээл авах, арвижуулах, дэлгэрүүлэх үйлийг эхлэх, угаал үйлдэх, хүүхэд үрчлэн авах, урлан бүтээхэд сайн. Улааны үйл, төлгө тавих, морь уралдахад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн ураги мөрөө гаргавал зохистой. Балжиннямтай өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

Цахим шууданд

## ГАРДАН ТУЛААНЫ АВАРГУУД ТОДОРЛОО



**Зэвсэгт хүчний 256 дугаар анги**

Ангийн 2021-2022 оны ангийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу гардан тулааны аварга шалгаруулах тэмцээнийг 36 хүртэлх насны эрэгтэй цэргийн алба хаагчдын дунд 6 жингийн төрөлд амжилттай зохион

байгуулж явууллаа. Тэмцээнд 170 гаруй цэргийн алба хаагч хурд, хүч, авхаалж самбаагаа сорьсноос 60 кг-ийн жинд цэргийн гэрээт алба хаагч Н. Мөнх-Эрдэнэ, 65 кг-ийн жинд дэд ахлагч Б.Батмэнд, 70 кг-ийн жинд дэд ахлагч Л.Дүвчин, 75 кг-ийн жинд ахлах дэслэгч Ц.Лхагвасүрэн, 80 кг-ийн жинд ахлагч Б.Бат-

Итгэл, 85 кг-ийн жинд ахлах ахлагч Б.Адъяахүү нар тус тус тэргүүн байр эзэллээ. Энэхүү тэмцээн нь Зэвсэгт хүчний гардан тулааны аварга шалгаруулах уралдаанд оролцох тамирчдын сорилго болсноороо онцлог байлаа.

**Хошууч Л.АМАРБАЯСГАЛАН**

## ЧУУЛГЫН БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ I ҮЕИЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ БАЙНА



мэргэжилтэн дэд хурандаа Н.Цоггэрэл, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нь” сэдвээр Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албаны Урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах мэргэжилтэн цагдаагийн ахлах дэслэгч Б.Ганхуяг нар лекц орж бие бүрэлдэхүүн бүрэн хамрагдлаа.

Мөн Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулга Монгол Улсын консерваторын Бүжиг циркийн мэргэжлийн сургуультай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд энэ 7 хоногт чуулгын бүжигчид ахисан түвшний сертификаттай сургалтад хамрагдаж байна.

Энэхүү сургалтаар сонгодог бүжгийн болон улс үндэстний бүжгийн дасгал, бүжгийн түүх, бүжгийн онолын хичээлүүдийг Монгол Улсын консерваторын Бүжиг циркийн мэргэжлийн сургуулийн мэргэжлийн багш нар удирдан явуулах юм.

**ЦДБЭЧ**  
Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан “ЦДБЭЧ-ын 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу чуулгын бие бүрэлдэхүүний I үеийн сургалт зохион байгуулагдаж байна. Энэ хүрээнд ЦДБЭЧ-ын

бие бүрэлдэхүүний хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, ажлын байрандаа суралцан хөгжих боломжийг бүрдүүлэх зорилгоор зохион байгуулагдаж буй тус сургалтад “Монгол Улсын Зэвсэгт хүчний Энхийг дэмжих ажиллагааны оролцоо цаашдын чиг хандлага” сэдвээр ЗХЖШ-ын АУГ-ын ЭДАХ-ийн ахлах

## СУМДАД ЦЭРГИЙН БҮРТГЭЛИЙН ШАЛГАН ТУСЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



**Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб**

2022 оны цэргийн бүртгэл явуулах тухай аймгийн Засаг даргын А/748 дугаар захирамжийн дагуу энэ сарын 6-10-ны өдрүүдэд Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал, Баянбулаг, Гурванбулаг, Заг, Жаргалант, Галуут, Баян-Овоо сумдад хяналтын тооллого явуулж, шалган туслах ажлыг зохион байгуулан ажиллалаа. Сумдад цэргийн

бүртгэлийг батлагдсан маягаар хэрхэн бүртгэл, судалгаа, мэдээг гаргаж байгаад хяналт тавьж, “E-mongolia” аппликэйшн ашиглан цахим хэлбэрээр бүртгүүлэх зааварчилгааг иргэдэд өглөө. Мөн төрийн болон албаны нууцыг хамгаалах журмын дагуу бүртгэлээр ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нууц хадгалалт, хамгаалалтыг чанд сахиулж, сумдад хадгалагдаж байгаа нууцын зэрэглэлтэй баримт бичгийн хадгалалтын

талаар зааварчилгаа өгсөн юм.

Аймгийн хэмжээнд цахим бүртгэл болох “E-mongolia” аппликэйшн ашиглан 938 иргэн бүртгүүлсэн байна. 2022 оны цэргийн бүртгэл аймгийн хэмжээнд өнөөдрийн байдлаар 84 хувьтай явагдаж байна. Түүнчлэн 2019-2021 онд цэргийн дүйцүүлэх албыг биеэр хаасан иргэдийн цэргийн үүрэгтний үнэмлэхийг гардуулан өгч амжилт хүслээ.



Гэрэл зургийн агшин



Гэрэл зургийг ахлах ахлагч Г.БАТ-ЭРДЭНЭ